



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/180

Чингис хот

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа зорчигчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавих, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд бүртгэл хийх, халуун хэмжих хяналтын цэгийг Хэрлэнгийн гүүрэнд байгуулж, хяналтын цэгт ажиллах албан хаагчдын эрүүл мэнд, ажиллах нөхцөл бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг Авто тээврийн төв /Б.Ганбат/, Онцгой байдлын газар /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, Эрүүл мэндийн газар /Ц.Гэрэлмаа/, Зооноз өвчин судлалын төв /Г.Наранхүү/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Бор-Өндөр, Норовлин, Цэнхэрмандал суманд хяналтын цэг ажиллуулахыг тус сумдын Засаг дарга нарт, удирдлага зохион байгуулалтаар хангахыг Онцгой байдлын газар /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус үүрэг болгосугай.

2. Хүн ам олноор цугларах үйлчилгээний байгууллага, хүүхдийн тоглоомын гадна талбайд хяналт тавьж эргүүл шалгалтыг тогтмол зохион байгуулахыг Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, Боловсрол, соёл урлагийн газар /С.Мөнхцэцэг/, сумдын Засаг дарга нарт, Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр иргэдэд шуурхай хүргэхийг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын дарга нарт, Төв штабын үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд шаардагдах тоног төхөөрөмжийг худалдан авч бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой байдлын газар /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-т тус тус даалгасугай.

3. Дээрх зардалд шаардагдах 6660000 /зургаан сая зургаан зуун жаран мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансны хандивын мөнгөнөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч бөгөөд Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Онцгой комиссын орлогч, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

D:\My Documents\Захирамж 2020.doc

Аймгийн Засаг даргын 2020 оны
03 дугаар сарын 30 өдрийн А/180
дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын нэр төрөл	Ажиллах хоног	Нэг өдрийн зардал	Мөнгөн дүн	Хянасан
1	Хоол хүнс	36	120.000	2160000	
Нийт				2160000	
Онцгой комиссын төв штабын байранд хэрэглэх тоног төхөөрөмж					
1	Зөөврийн компьютер			3200000	
2	Өнгөт принтер			1000000	
3	Дуу хураагуур			300000	
Нийт				4500000	
Бүгд				6600000	